

## ОЛОН УЛСЫН ЭМНЭЛГИЙН СТАНДАРТУУДЫГ ХАНГАСАН

СХДНЭ нь олон улсын эмнэлгийн стандартуудыг хангасан Монголын анхны дүүргийн эмнэлэг бөгөөд барилга байгууламж, тоног төхөөрөмж, эмч, боловсон хүчний хувьд “жишиг” болохуйц олон давуу талуудтай.

- Галын аюулын үед өвчтөн, эмч, эмнэлгийн ажилтан, эмнэлгийн тоног төхөөрөмж, барилга бүрэн хамгаалагдсан гал хамгаалах системтэй
- Эмнэлгийг барихад ашигласан дотор заслын бүх материалууд галд тэсвэртэйн дээр бактери үрждэггүй
- Салхивч, агааржуулалт, хөргөлт, хүчилтөрөгчийн системтэй
- Цахилгаан болон цэвэр усны нөөц эх үүсвэртэй
- Дээрх бүгдийг ухаалгаар удирддаг барилгын удирдлагын системтэй
- Автомашны нэмэлт орц гарцтай
- Гаднаа 200 автомашины зогсоолтой

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС БЭРХШЭЭЛГҮЙ ҮЙЛЧЛҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан автомашины зогсоол
- Тэргэнцэр саадгүй явах налуу хашлага
- Босгогүй гадна болон дотор хаалга
- Товгор хөтөчтэй зам
- Тоноглогдсон ариун цэврийн өрөө
- Тэргэнцэртэй хүмүүст тохиромжтой байрласан гэрлийн унтраалга, цахилгаан шатны товчлуурууд
- Давхарууд ханын бэхлэгээгээр бүрэн тоноглогдсон
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн тэргэнцэрийн түвшинд хүртэл өндрийг нь тохируулах боломжтой эмэгтэйчүүдийн үзлэгийн ор



Сонгинохайрхан Дүүргийн Нэгдсэн Эмнэлгийг Монгол улсын Засгийн Газар, Азийн Хөгжлийн Банк, Эрүүл Мэндийн Салбарын Хөгжил Хөтөлбөр-4, 4+ төслийн хүрээнд барьж, ашиглалтанд оруулсан.




## ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН АЯ ТУХ

- Эмчлүүлэгчдийн өрөө бүрт ариун цэврийн өрөөтэй
- Сувилагч дуудах системгйг ор болон ариун цэврийн өрөөнд, суултуурын дэргэд суурилуулсан
- Өвчтний ор бүрийг хүчилтөрөгчийн шууд хангамжид холбосон
- Эмчилгээний орыг үйлчлүүлэгчийн биеийн байдлаас хамааруулан өөрчлөн зохион байгуулах боломжтой
- Үзлэг, шинжилгээний цагийг утсаар, интернетээр болон биеэр авах боломжтой
- Амбулаториор үйлчлүүлэгч болон хэвтэн эмчлүүлэгчдэд үйлчлэх нэгдсэн эмийн сантай
- Кофе шолтой

## ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДУРАН, ЭМНЭЛГИЙН БАГАЖ ХЭРЭГСЛИЙГ АРИУТГАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

СХДНЭ-т суурилагдсан ариутгалын цогц төхөөрөмжүүд нь эмнэлгийн багаж хэрэгслүүдийг дээд зэргийн чанартайгаар ариутгадаг бөгөөд энэ нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлдэг.

## ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ БОЛ




70174400 дугаарын  
утсанд холбогдоно




Эмнэлэгт шууд ирж тусламж  
үйлчилгээ авна

## ЭМЧИД ҮЗҮҮЛЭХ БОЛ



72728282 дугаарын утсанд  
холбогдон цаг авна



Товлосон цагтаа эмнэлэгт ирж  
тусламж үйлчилгээ авна

Эмнэлгийн тусламж  
үйлчилгээг авахдаа  
бүрдүүлэх материал

- Иргэний цахим үнэмлэх
- Зарим тохиолдолд Эрүүл мэндийн даатгал төлсөн баримт

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТАНИЛЦУУЛГА



Сонгинохайрхан дүүргийн 19-р хороо  
Үйлдвэрчний эвлэлийн гудамж  
70174040  
Сонгинохайрхан Нэгдсэн Эмнэлэг  
shdne.ub.gov.mn  
skhd@shdne.ub.gov.mn

## ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

### Хэвтүүлэн эмчлэх

Жилд нийт 150.000 хүнд үйлчлэх хүчин чадалтай,  
250 ор бүхий хэвтэн эмчлүүлэх хэсэгтэй

### Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээнүүд:

1. Хүүхдийн тасаг
2. Дотор (хоол боловсруулах, зүрх судас, уушиг, дотоод шүүрэл)-ын тасаг
3. Мэс заслын тасаг
4. Мэдрэлийн тасаг
5. Эрчимт эмчилгээний тасаг

### Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ:

1. Жирэмсний хяналт
2. Эмэгтэйчүүдийн үзлэг
3. Эмэгтэйчүүдийн оношилгоо
4. БЗДХ



## АМБУЛАТОРИ

Амбулатори нь дараах үндсэн чиглэлийн тусламж үйлчилгээг үзүүлэх нийт 28 кабинеттэй:

1. Зүрх судасны кабинет
2. Дотрын кабинет (амьсгал, хоол боловсруулах болон шээс ялгаруулах эрхтний кабинет)
3. Дотоод шүүрлийн кабинет
4. Арьсны өвчин судлал, харшил
5. Эмгэг судлал
6. Сэтгэцийн кабинет
7. Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэнд судлал
8. Насжилт, настны кабинет
9. Чих, хамар, хоолой
10. Нүдний кабинет
11. Гэмтэл, мэс засал
12. Хавдар, хөнгөвчлөх эмчилгээ
13. Шүд, эрүү нүүрний тусламж үйлчилгээ
14. Эх барих, эмэгтэйчүүд, жирэмсний хяналт
15. Халдварт өвчин, ДОХ/БЗДХ
16. Сүрьеэ



## ОНОШИЛГОО

Өрхийн эрүүл мэндийн төв болон амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасгийн илгээсэн үйлчлүүлэгчдэд доорх аппарат тоног төхөөрөмжийн тусламжтайгаар оношлогоо, шинжилгээ, шаардлагатай тохиолдолд эмчилгээ хийнэ.

1. Компьютерт томографи
2. Рентген шинжилгээ (хөхний болон шүдний)
3. Хэт авиан шинжилгээ (зүрхний болон дотор эрхтний, жирэмсний болон эмэгтэйчүүдийн)
4. Дуран (ходоод, уушги, нарийн бүдүүн гэдэс болон бөөрний)
5. Тархины цахилгаан бичлэг
6. Аудиометр
7. Зүрхний цахилгаан бичлэг (энгийн болон ачаалалтай)
8. Судасны бичлэг

## ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ

1. Биохимийн шинжилгээ
2. Цусны бүлэг, резус фактор
3. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
4. Шээсний ерөнхий шинжилгээ
5. Цус бүлэгнэлтийн шинжилгээ
6. Үе мөчний үрэвслийн шинжилгээ
7. Вирусийн маркер
8. БЗДХ-н шинжилгээ
9. Микробиологийн шинжилгээ
10. Хавдрын маркер
11. Бамбай булчирхайн үйл ажиллагаа



## ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ

Онош болон биеийн байдлын хувьд хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй үйлчлүүлэгчдэд өдрийн цагаар эмчлэх, хянах, жижиг хэмжээний мэс ажилбар хийх, сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлдэг.

### Өдрийн тусламж үйлчилгээнүүд:

1. Дотор (Зүрх судас, хоол боловсруулах эрхтэний эмгэг, бөөр, дотоод шүүрэл)
2. Мэдээгүйжүүлэлт (өвчин намдаах)
3. Арьсны өвчин судлал / харшил
4. Гемодиализ
5. Сэргээн засах эмчилгээ
6. Жижиг мэс ажилбар
7. Дурангийн оношилгоо, эмчилгээ
8. Уламжлалт анагаах ухаан
9. Химийн эмчилгээ
10. Гэмтлийн мэс заслын тусламж үйлчилгээ

